



Я.САРАНСҮХ

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТАД
АЖИЛЛАХ ШИНЖЭЭЧИЙН
АЖЛЫН ДААЛГАВАР**

2022 оны 5 сарын 09 өдөр

Дугаар ЧАС-АД/22-022

Улаанбаатар хот

Ажлын зорилго: Шинжээч нь Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийх аудитад судалгаа, дүн шинжилгээ хийх, мэргэжлийн дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулах, аудиторуудад арга зүйн зөвлөгөө өгөхөд энэхүү ажлын зорилго оршино.

Ажил гүйцэтгэх хугацаа: Шинжээч нь 2022 оны 5 дугаар сарын 16-ны өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийг хүртэлх хугацаанд ажиллаж, шаардлагатай тохиолдолд Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг УИХ-аар хэлэлцүүлэх үе шатанд аудитын тодруулга, тайлбар бэлтгэж ирүүлнэ.

Байршил: Үндэсний аудитын газрын байр болон Сангийн яамны 9 дүгээр давхрын хурлын өрөөнд байрлан ажиллана.

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд “Аудитын сэдэв батлах тухай” Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалын дагуу “Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”-д аудит хийнэ.

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно” гэж заасны дагуу ажил гүйцэтгэх, шаардлагад нийцсэн мэргэшсэн, ажлын туршлага бүхий шинжээчийг аудитад оролцуулна.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ

Шинжээч нь Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газрын аудитын багийн бүрэлдэхүүнд орж дараах чиглэлүүдээр судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт зөвлөмж боловсруулах, аудитад туслах, арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

2.1 Монгол Улсын төсөв, мөнгөний бодлого уялдаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх;

2.2 Монгол Улсын 2021 оны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд баримталсан бодлого, чиглэл нь төсвийн тогтвортой байдал, “Алсын хараа 2050”, Монгол Улсыг хөгжүүлэх 2021-2025 оны төлөвлөгөө, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан эсэхэд дүн шинжилгээ хийх;

2.3 Засгийн газрын 2021 оны “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө” батлах тухай 42 дугаар тогтоолын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж өгөх;

2.4 Эрүүл мэндийн салбарын шинэчлэл, гүйцэтгэлд суурилсан төсвийн гүйцэтгэлийн үр дүнг судалж, дүгнэх;

2.5 Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хөрөнгийн зарцуулалтад дүн шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж өгөх;

2.6 Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд судалгаа, дүн шинжилгээ хийх;

2.7 Ковид-19 цар тахлын үед хэрэгжсэн төсвийн зарцуулалтын талаар дүн шинжилгээ хийх;

2.8 Засгийн газрын өрийн тайлан, гадаад валютын нөөцийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнд дүн шинжилгээ хийх, дүгнэлт өгөх;

2.9 Өмнөх оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх;

2.10 Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11.1.4 “төсвийн гүйцэтгэл нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг хэрхэн хангасан байдалд дүн шинжилгээ хийх”; 14.1 “Засгийн газар төсвийн тусгай шаардлагыг хэрхэн хангасан тухай дүгнэлт, тайланг бэлтгэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаж, Улсын Их Хуралд тайлагнана.”; 14.2 “Энэ хуулийн 14.1-д заасан төсвийн гүйцэтгэлийн тайланд төрийн аудитын төв байгууллага аудит хийхдээ төсвийн тусгай шаардлагыг хэрхэн хэрэгжүүлсэн байдалд дүгнэлт гаргана” гэж заасны дагуу дүгнэлт, зөвлөмж гаргах;

2.11 Аудитын дүнд үндэслэн санал, дүгнэлт, зөвлөмжийн төсөл боловсруулах, аудитын багт арга зүйн зөвлөгөө өгөх.

Шинжээч нь Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч, Аудитын хоёрдугаар газрын захирал, аудитын менежер болон ахлах аудиторовн өгсөн чиглэл, арга зүйн дагуу аудитыг гүйцэтгэнэ.

Аудитын явцад олж авсан мэдээллийг төрийн аудитын үйл ажиллагаанд ашиглахаас өөр зорилгоор хөндлөнгийн этгээдэд дамжуулах, хувийн буюу бусдын ашиг сонирхлын төлөө ашиглуулах эрхгүй бөгөөд мэдээллийн нууцыг чанд хадгална.

Шинжээч аудитыг гэрээний хугацаанд багтаахын тулд илүү цагаар ажиллана.

ГУРАВ. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Шинжээч нь Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудитыг гүйцэтгэх Аудитын хоёрдугаар газрын аудитын багийн бүрэлдэхүүнд орж ажиллах ба байгууллага дээр багийн хамт очиж аудитыг гүйцэтгэнэ.

Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Улсын төсвийн, Орон нутгийн, Эрүүл мэндийн даатгалын болон Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, холбогдох бусад баримт материалыг хамруулна.

ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Шинжээч нь ажлын даалгаварт тусгагдсан зорилгыг хэрэгжүүлж, ажил үүргийн хуваарийн дагуу хамрах хүрээний ажлыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-д нийцүүлэн гүйцэтгэж, аудитын гүйцэтгэлийн үе шатанд судалгаа, дүн шинжилгээ, тооцоолол хийж, тайлагналын үе шатанд аудитын тайлан бичиж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулах бөгөөд ажлын баримтыг аудитын багт цаасан болон цахим хэлбэрээр хүлээлгэж өгнө.

Ажлын даалгаварт заасан ажил үүргийг гүйцэтгэхдээ ахлах аудитор, аудитын менежер, газрын захирал, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогчийн өгсөн чиглэлийн дагуу тухай бүр чанартай, түргэн шуурхай гүйцэтгэж, аудитын дүгнэлт, зөвлөмж, ажлын тайлан бэлтгэсэн байна.

ТАВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Гүйцэтгэх ажил үүргийн хүрээнд аудитыг гүйцэтгэж байгаа шинжээч нь Аудитын хоёрдугаар газрын аудитын багтай хамтран ажиллах бөгөөд шаардлагатай дэмжлэг, туслалцааг тус газраас үзүүлнэ.

Ажлын даалгаврыг гүйцэтгэхээр шалгарсан шинжээч нь ажил эхлүүлэх болон үүсэж болзошгүй хүндрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлж, захиалагч /Үндэсний аудитын газар/-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллаж болно.

Аудитын явцад илэрсэн зөрчил, шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн бол тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.

ЗУРГАА.ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН АЖЛЫН ТУРШЛАГА

Шинжээч нь Үндэсний аудитын газартай хамтран ажиллахад аудитын үйл ажиллагаатай холбоотой төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийг задруулахгүй байх, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн байх бөгөөд иж бүрэн түншлэлийн чиглэлээр хамтран ажиллана.

Тавигдах шаардлага болон ажлын туршлагын хүрээнд шинжээч нь

- Төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлээр макро түвшний судалгаа, дүн шинжилгээ хийж байсан ажлын туршлагатай;
- Санхүү, эдийн засгийн мэргэжилтэй;
- Санхүү, эдийн засгийн чиглэлээр эрдмийн зэрэг, цолтой;
- Мэргэжлийн гадаад хэлний мэдлэгтэй.

ДОЛОО. АЖЛЫН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ажлын цагийн үзүүлэлтүүд		1-р долоо хоног /V.16-V.20/	2-р долоо хоног /V.23-V.27/	3-р долоо хоног /V.30-VI.03/	4-р долоо хоног /VI.06-VI.10/	5-р долоо хоног /VI.13-VI.17/	Нийт
Ажиллах хоног		5	5	5	5	3	23
Өдөрт ажиллах цаг		8	8	8	8	8	184
Аудитын үе шат	Гүйцэтгэх						
	Тайлагнах						

НАЙМ . ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Шинжээчийн ажлын хөлсийг харилцан тохиролцож гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу ажлын гүйцэтгэлд үндэслэн олгоно.

___000___

ОРОЛЦОХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

[2022.....]

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Танай [он, сар, өдөр]-ийн шинжээч сонгон шалгаруулах зар/урилга болон өөрсдийн оролцох хүсэлтийн дагуу бид [.....дүгнэлт гаргах ажилд / тоогоор үсгээр төгрөгөөр гүйцэтгэх саналыг үүгээр хүргүүлж байна. /төсвийн тооцооллыг хавсаргав./

Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн

ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН АХЛАГЧ /...../

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

холбоо барих утас:

ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

3.1. Ерөнхий танилцуулга

.....

.....

(Оролцогч хуулийн этгээд нь ерөнхий танилцуулгад холбогдох үйл ажиллагаа явуулах бүртгэлийн болон эрхийн гэрчилгээг хавсаргаж ирүүлнэ)

3.2. Хуулийн этгээд/баг/хувь хүний чадварыг харуулж чадах сүүлийн 3 жилд үзүүлсэн ижил, төстэй үйлчилгээний мэдээлэл

Доорх хүснэгтийн дагуу хуулийн этгээд нь дангаараа болон хамтарч албан ёсоор үзүүлсэн үйлчилгээ бүрийн тухай мэдээлнэ үү. Нотлох баримтыг хавсарган ирүүлэх шаардлагатай.

Гүйцэтгэсэн ажлын нэр:		Улсын нэр:
Байршил:		Танай байгууллагаас ажилласан мэргэжилтэн (чиглэл):
Захиалагчийн нэр:		Ажилтны тоо:
Хаяг:		Гүйцэтгэсэн ажлын хугацаа, хүн-сарын тоо:
Эхэлсэн он сар өдөр:	Дууссан он сар өдөр:	Ажлын өртөг (сая төгрөгөөр) ойролцоогоор:
Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн нэр (хэрэв байвал):		Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн ажилтнуудын ажилласан сарын тоо:
Голлох мэргэжилтэн: (Төслийн удирдагч/зохицуулагч, төслийн ахлагч)-ийн гүйцэтгэсэн ажил, үүргүүд:		
Төслийн талаарх товч танилцуулга:		
Төслийн хүрээнд танай ажилтны гүйцэтгэсэн үндсэн үйлчилгээний талаарх танилцуулга:		

Хуулийн этгээд/баг/хувь хүний нэр: _____

САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ МАЯГТ

Санал болгож буй албан тушаал: _____

Байгууллагын нэр: _____

Мэргэжилтний нэр: _____

Мэргэжил: _____

Төрсөн он, сар, өдөр: _____

Тухайн байгууллагад ажилласан жил: _____ Иргэншил: _____

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: _____

Хариуцах ажил: _____

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Мөн нотлох баримтыг материалд хавсарган ирүүлэх шаардлагатай]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшнийг ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ¹

№	Нэр	Хаяг, байршил	Хүчин чадал
1	Ажлын байр		
2	Тоног төхөөрөмж		

БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Нэр	Албан тушаал	Хариуцах ажил

АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

- Ажлын хөтөлбөрийг дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээр гаргаж ирүүлнэ.
- Ажил гүйцэтгэх аргачлалыг дэлгэрэнгүй гаргаж ирүүлнэ.

Баталгаажуулах

¹ Ажлын байр, тоног төхөөрөмжийн зургийг хавсаргаж ирүүлнэ.